



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/520

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдсэн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар “Буянт голыг хөндлөн гарсан замын гарцуудыг хаах ажил”-д зориулан 5 159 500 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 5 159 500 төгрөг /таван сая нэг зуун тавин есөн мянга таван зуу/-ийг аймгийн байгаль хамгаалах сангийн 4.3-д тусгагдсан “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бодлого зорилтыг хэрэгжүүлэх” арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. “Буянт голыг хөндлөн гарсан замын гарцуудыг хаах ажил”-ын зардлыг хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/520 Ch

Аймгийн Засаг даргын 2020 оны
09 дүгээр сарын 16-ны өдрийн
А/520 дугаар захирамжийн хавсралт

“БУЯНТ ГОЛЫГ ХӨНДЛӨН ГАРСАН ЗАМЫН ГАРЦУУДЫГ
ХААХ АЖИЛ”-ЫГ ГҮЙЦЭТГЭХ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

№	Үйл ажиллагаа	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төг/	Нийт дүн /мян.төг/	Тайлбар
1	Замын хаалтын ажил	багц	1	4 599 305	4 599 305	Шонгийн нүх гараар ухах, нүхийг бетоноор цутгах, турба гагнаж хаалт хийх, турбааг тосон будгаар будах
2	Бусад	багц	1	560 195	560 195	НӨАТ, захиалагчийн хяналтын зардал, зураг, төсөв
Дүн					5 159 500	

-оОо-